



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

*дадт* оны *26* сарын *15* өдөр

Дугаар *Бэлгээ*

Улаанбаатар хот

Ч.Батсүхэд ёс зүйн хариуцлага  
хүлээлгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар 37.1.7 дахь заалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.1.3, 7.1.7 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.1, 16.1.3 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1716 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 10.4, 10.6 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн хяналтын улсын байцаагч Чойсүрэнгийн Батсүх ёс зүйн зөрчил гаргасан нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 05 дугаартай хурлын тэмдэглэл, мөн өдрийн 05 дугаартай дотоод албан бичгээр ирүүлсэн дүгнэлтээр тогтоогдсон тул түүнд 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрөөс байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах ёс зүйн хариуцлага хүлээлгэсүгэй.

2. Өдөр тутмын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, байгууллагын соёл, дэг журам, албан харилцааны ёс зүйг чанд сахиж ажиллахыг хяналтын улсын байцаагч Ч.Батсүхэд үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс /С.Оюун-Эрдэнэ/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

142401364